

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2009 оны 11 дүгээр сарын
23-ны өдөр

Дугаар 396, 426.

Улаанбаатар хот

Дархлаажуулах төлөвлөгөө батлах тухай

Томуугийн цартахлын А /H1N1/ вирусийн халдвартай тэмцэх, сэргийлэх хариу арга хэмжээг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Томуугийн цартахлын А/H1N1/ вирусийн халдварын эсрэг вакциныг шуурхай түгээх, дархлаажуулах төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. ДЭМБ-аас гаргасан зөвлөмжийн дагуу томуугийн цартахлын А/H1N1/ вирусийн халдварын эсрэг вакцинаар үг төлөвлөгөөний дагуу дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, хэлтсийн дарга нарт даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд /Ж.Цолмон/, Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга /Д. Намсрай/ нарт даалгасугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД




С.ЛАМБАА

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮН
КОМИССАР



ЦАМГАЛАНБАЯР



Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын
 ерөнхий газрын даргын хамтарсан 2009
 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн
 ...426... тоот тушаалын хавсралт

**ТОМУУГИЙН ЦАРТАХЛЫН А/Н1N1/ ВИРУСИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ
 ВАКЦИНЫГ ШУУРХАЙ ТҮГЭЭХ, ДАРХЛААЖУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Улаанбаатар хот
 2009 оны 11 дүгээр сар

АГУУЛГА

Товчилсон үгсийн жагсаалт

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ОРШИЛ

- 1.1. Томуугийн цартахлын вакциныг шуурхай түгээх, дархлаажуулах үндэсний төлөвлөгөөний тухай
- 1.2. Зорилго, зорилтууд

ХОЁРДУГААР БҮЛЭГ. УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТ

- 2.1. Удирдлага, зохион байгуулалт
- 2.2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын ажил үүргийн хуваарь

ГУРАВДУГААР БҮЛЭГ. МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО

- 3.1. Мэдээллийн тогтолцоо, урсгал
- 3.2. Харилцаа холбооны дэд төлөвлөгөө

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ВАКЦИНЫ ХҮЙТЭН ХЭЛХЭЭ, ШУУРХАЙ ТҮГЭЭЛТ, ДАРХЛААЖУУЛАЛТ

- 4.1. Вакцины хүйтэн хэлхээ
- 4.2. Дархлаажуулах
- 4.3. Зардлын тооцоо

ТАВДУГААР БҮЛЭГ. ХҮНИЙ НӨӨЦ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

- 5.1. Хүний нөөцийн менежмент
- 5.2. Ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй байдал
- 5.3. Вакцин, дагалдах хэрэгслийн аюулгүй байдал

ЗУРГАДУГААР БҮЛЭГ. ТОМУУГИЙН ЦАРТАХЛЫН ВАКЦИНААР ДАРХЛААЖУУЛАХ ҮЕД ҮҮССЭН ЭМНЭЛГИЙН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

- 6.1. Эмнэлгийн хог хаягдлын менежмент

ДОЛДУГААР БҮЛЭГ. ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ

- 7.1. Явцын хяналт, үнэлгээ
- 7.2. Тайлан бичих

ЛАВЛАГАА НОМ ЗҮЙ ХАВСРАЛТУУД

Товчилсон үгийн жагсаалт

БОЭТ	Бүсийн оношлогоо эмчилгээний төв
ВШЗ	Вакцин шошгоны заалт
ДДУХ	Дархлаажуулалтын дараах урвал хүндрэл
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗТАЖЯ	Зам, тээвэр, аялал жуулчлалын яам
НЭ	Нэгдсэн эмнэлэг
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОБХ	Онцгой байдлын хэлтэс
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХХХК	Хүйтэн хэлхээний хянах карт
СЯ	Сангийн яам
ТТБ	Төрийн бус байгууллага
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМН	Эрүүл мэндийн нэгдэл
МУЗН	Монголын улаан загалмай нийгэмлэг
SAGE	Шинжээчдийн стратегийн зөвлөх баг гэсэн англи үгийн товчлол

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Оршил

1.1. *Томуугийн цартахлын вакциныг шуурхай түгээх, дархлаажуулах үндэсний төлөвлөгөөний тухай*

Тус төлөвлөгөө нь томуугийн цартахлын бэлэн байдал, хариу арга хэмжээг хангах Монгол улсын үндэсний төлөвлөгөөний нэг бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд томуугийн цартахлын вакциныг 7 хоног¹-ийн хугацаанд хамгийн эцсийн цэгт хэрэглэгчдэд хүргэх, дархлаажуулах үйл ажиллагааг удирдлага, мэргэжил арга зүйгээр хангах үндсэн хэрэгсэл болно.

Энэхүү төлөвлөгөөнд удирдлага зохион байгуулалт, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын ажиг үүргийн хуваарь, мэдээлэл, харилцаа холбоо, вакцины хүйтэн хэлхээ, шуурхай түгээлт, хүний нөөц, аюулгүй байдал зэрэг бүлгүүд орсон.

1.2. *Зорилго, зорилтууд*

Зорилго: Томуугийн цартахлын үеийн өвчлөл, эндэгдлийг бууруулах, хор хохирол багатай даван туулах.

Зорилтууд:

1. Томуугийн цартахлын вакцин, дагалдах хэрэгслийг улсын гааль дээр импортоор оруулж ирснээс хойш 7 хоногийн дотор эцсийн хэрэглэгчдэд хүргэх.
2. Томуугийн цартахлын вакциныг дархлаажуулах эцсийн нэгжид хүргэсний дараах 5-7 хоногт багтаан дархлаажуулах

1.3 *Томуугийн цартахлын вакцины хэрэгцээ, тооцоо:*

Томуугийн цартахлын А(Н1N1) вирусээр үүсгэгдсэн өвчлөл 2009 оны 4 дүгээр сард АНУ, Мексик улсад бүртгэгдэж, улмаар дэлхийн улс орнуудад тархаж, өвчлөл нас баралтын тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор 6 дугаар сарын 11-нд ДЭМБ томуугийн цартахлын А(Н1N1) вирусийн халдварын тархалт цартахлын 6 дугаар шат буюу ид үедээ орсныг албан ёсоор зарласан билээ.

2009 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн ДЭМБ-ын албан ёсны мэдээгээр ДЭМБ-ын 6 бүсийн 197 улсад цартахлын А(Н1N1) вирусээр үүсгэгдсэн халдварын 496.471 батлагдсан тохиолдол, 4999 нас баралт тус тус бүртгэгдээд байна.

Шинжээчдийн Стратегийн Зөвлөх Баг (SAGE)-ийн 2009 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хурлаар дэлхий дахинд эмч, эмнэлгийн ажилчдыг эхний ээлжинд

¹ Улирлаг томуугийн вакцин тариулснаас хойш хүний биед үүссэн хамгаалах чадвар (HI test) дунджаар 14 хоногийн дараа хэмжигдэхүйц хэмжээнд хүрдэг. Энэ нь томуугийн халдвараас аль болох эрт үед нь хамгаалж, өвчний тархалтыг бууруулан, вакциныг илүү үр дүнтэй хэрэглэх шаардлага дээр үндэслэсэн тооцоо юм. Цагаанцэцэг өвчнийг дэлхий дахинаа устгасан амжилт үүнтэй ижил зарчмаар явагдсан бөгөөд өдгөө ч халдварт саа өвчнийг зарим бүс нутгуудад мөн ийм зарчмаар устгахаар зорьж байгаа билээ.

*Томуугийн цартахлын А/Н1N1/ вирусийн халдварын эсрэг вакцинаар дархлаажуулахыг улс орнуудад зөвлөөд байна.

Манай улсад сүүлийн 3 жилийн байдлаар жилд амбулаториор үйлчлүүлэгсдийн дунд томуу, томуу төст өвчтэй гэж оношлогдогсод дунджаар 4.0%-ийг эзэлж, 10.000 хүн амд дунджаар 834.2 тохиолдол бүртгэгдсэн байна. 2006/07, 2007/08 оны томуугийн улирлын хувьд дэгдэлт хожуу эхэлж, хавар 2, 3 дугаар сарын сүүлчээр оргил үедээ хүрсэн байна). Насны хувьд бүх насныхан өвчилж, 15 хүртэлх насны хүүхэд нийт өвчлөлийн 80-85%-ийг, түүн дотроо 9 хүртэлх насны хүүхдийн өвчлөл 70 орчим хувийг эзлэх явдал жил бүр давтагдаж байна.

Энэ оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд томуугийн цартахлын А/Н1N1/ вирусийн халдварын лабораториор батлагдсан 1106 тохиолдол бүртгэгдэж 18 хүн нас бараад байна.

ДЭМБ-аас томуугийн цартахлын эсрэг вакцинд хамруулахаар зөвлөж буй хүн амын эрсдэлт бүлэг, өөрийн орон дахь өвчлөлийн тархвар судлалын байдал, вакцины хүрэлцээ зэргийг үндэслэн тархвар судлалын заалтаар дархлаажуулах тооцоог дараах үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөв. (Хүснэгт 1) Үүнд:

1. I үе шат - 2009 оны 12 сард, ДЭМБ-аас хангаж буй 100000 хүн тун (нийт хүн амын 4 хувийг хамруулах)
2. II үе шат - 2010 оны I улиралд, ДЭМБ-аас хангаж буй 170000 хүн/тун, Монгол улсын Засгийн газраас хангаж буй 60000 хүн тун вакцин (нийт хүн амын 6 хувийг хамруулах)
3. III үе шат - 2010 оны I улиралд (нийт хүн амын 15 хувийг хамруулах)
4. IV үе шат -Сайн дурын дархлаажуулалтын хэлбэрээр нийт хүн амын 35 хувийг хамруулах

Вакциныг бүртгэх зөвшөөрөл:

Томуугийн цартахлын вакциныг Эрүүл мэндийн яам бүртгэн эмийн болон халдварт өвчин- тархвар судлалын салбар зөвлөлийн хамтарсан хурлаар хэлэлцэн хэрэглэх зөвшөөрөл олгоно.

*Томуугийн цартахлын А/Н1N1/ вирусийн халдварын эсрэг вакциныг цаашид "Томуугийн цартахлын вакцин" гэнэ.

Хүснэгт 1. Томуугийн цартахлын вакцинаар хүн амыг дархлаажуулах тооцоо

№	Хамруулах зорилтот бүлэг	Хамрагдах хүний тоо	Шаардагдах вакцин хүн/тун
I үе шат (Хүн амын 4 хувийг хамруулах)			
1.	Халдвартай нөхцөлд ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтэн	23000	30000
2	Онцгой байдал, хил гааль, мэргэжлийн хяналт, агаарын болон төмөр замын тээврийн зайлшгүй шаардлагатай албан хаагчид	15000	19000
3	Жирэмсний 20 долоо хоногоос дээш хугацаатай жирэмсэн эмэгтэйчүүд	26000	34000
4	Уушигны архаг эмгэгтэй хүмүүс / багтраа, архаг хатгаа, гуурсан хоолойн тэлэгдэх өвчин.... гм/	13000	17000
5	БҮГД	77000	100000
II үе шат (Хүн амын 6 хувийг хамруулах)			
1.	Эмнэлгийн эмч, мэргэжилтэн	10010	13000
2	1-5 насны хүүхэд	111057	144230
3	Эрсдэлт бүлгийн хүн ам	56033	72770
4	БҮГД	177100	230000
III үе шат (Хүн амын 15 хувийг хамруулах)			
1	6-15 насны хүүхэд	224295- Аймгийн төв 180705 – УБ хот	
2	БҮГД	405000	526500
IV шат (Хүн амын 35 хувь буюу 945000 хүнийг хамруулах)			

Тайлбар: 1. Вакцин нийлүүлэгдэх үед өвчлөлийн тархвар зүй, эмнэлзүйн нөхцөл байдлыг харгалзан зорилтот бүлэг, хамрах хүрээг өөрчилж болно.
2. Улаанбаатар хот болон аймгийн төвд амьдарч байгаа 1-15 насны хүүхдийг дархлаажуулахаар тооцсон.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Удирдлага, төлөвлөлт

2.1. Удирдлага, зохион байгуулалт

Томуугийн цартахлын вакциныг шуурхай түгээх үйл ажиллагааг улс, аймаг/дүүрэг, сум, өрхийн эмнэлгийн түвшинд тусгайлан томилогдсон комисс удирдан зохион байгуулна. Комиссын бүрэлдэхүүн, ажил үүргийн чиглэлийг /Хүснэгт 2/ тухайн шатлалын комиссын гишүүдийн мэдээллийг Хавсралт 1-д тус тус нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 2

Томуугийн цартахлын вакциныг шуурхай түгээх бүх шатны комиссын бүрэлдэхүүн, ажил үүргийн чиглэл

Албан тушаал	Байгууллага	Гүйцэтгэх үүрэг
Дарга	Эрүүл мэндийн дэд сайд	<ol style="list-style-type: none"> 1. Комиссын ажлыг удирдан зохион байгуулна. 2. Салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог хангана. 3. Томуугийн цартахлын вакциныг түгээх үндэсний төлөвлөгөөтэй уялдуулан холбогдох дэд төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлнэ. 4. Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, эцсийн үр дүнд хяналт тавин холбогдох байгууллагуудад (хандивлагчид болон засгийн газарт) тайлагнана.
Нарийн бичгийн дарга	ХӨСҮТ-ийн тандалт, сэргийлэлт хариуцсан дэд захирал	<ol style="list-style-type: none"> 1. Төлөвлөгөөг хэрэгжүүлэн явцыг тухай бүрт баримтжуулна. 2. Мэдээ тайланг нэгтгэн тайлагнана. 3. Вакцин, дагалдах хэрэгслийг түгээх үеийн харилцаа холбоогоор хангана. 4. Цагийн байдалтай уялдуулан яаралтай шийдвэрлэх асуудлыг хүлээн авч шийдвэрлүүлнэ.
	ЭМЯ	<ol style="list-style-type: none"> 1. Вакцины холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн улсын хилээр нэвтрүүлнэ. 2. Хүн хүч, тоног төхөөрөмжийн нэмэлт нөөцийг судалгааг гаргасан байна. 3. Вакцин түгээх ажилд оролцож буй ажилтнуудын эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдлыг хангана. 4. Вакцин, дагалдах хэрэгслийн хадгалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлыг хангана 5. Дархлаажуулалтын явцад үүсэх хог хаягдлын менежментийг зохицуулна. 6. Вакцин түгээх бэлтгэл ажлыг хангана. <ul style="list-style-type: none"> • Вакциныг шаардлагатай тоо хэмжээг төлөвлөх; • Вакцин, дагалдах хэрэгслийн тооцоог гаргах (зүү

		<p>тариур, аюулгүй хайрцаг, хүйтэн сав, вакцин зөөврийн сав, мөсөн элемент, хэм заагуур);</p> <ul style="list-style-type: none"> • Томуугийн цартахлын вакцины хадгалах, тээвэрлэх багтаамжийг үндэсний төв, аймаг, дүүрэг, сум тус бүрээр тооцоолох; • Вакцины багтаамжийн тооцоон дээр үндэслэн вакцин хадгалах агуулах байр савыг бэлэн болгох; • Цартахлын вакцины шуурхай түгээлтэнд оролцох нэмэлт хүн хүчийг сургах; • Вакцин түгээх хуваарь, зураглал, тээврийн хэрэгслийн төрөл, маршрутыг гаргах; <p>7. Вакцин, дагалдах хэрэгслийг эцсийн хэрэглэгчдэд түгээх ажлыг гардан зохион байгуулна.</p> <p>8. Нэгжүүдээс вакцин хүлээн авсан мэдээг авч улсын комисст хүргэнэ.</p>
Гишүүд	ОБЕГ	<ol style="list-style-type: none"> 1. Вакцин дагалдах хэрэгслийг түгээх явцад учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээг урьдчилан хийж, эрсдэл учирсан тохиолдолд асуудлыг шуурхай шийдвэрлэх. 2. Вакцин, дагалдах хэрэгсэлийг хүлээн авах нэгжийн байршлын зураглал, тээврийн хэрэгслийн төрөл, маршрут, төвөөс аймаг/дүүрэг, аймаг/дүүргээс сум/өрхийн эмнэлэг хүртэл тээвэрлэх хугацааг нарийвчлан гаргасан байх. 3. Харилцаа холбооны дэд төлөвлөгөөг гардан хэрэгжүүлэх. 4. Ажилтан, вакцин, дагалдах хэрэгслийн тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлыг хангах. 5. Үндэсний болон орон нутгийн төлөвлөгөөг турших дасгал сургуулиалтыг зохион байгуулах. 6. Нэмэлтээр ажиллах хүн хүч, тоног төхөөрөмжийн судалгааг урьдчилан гаргаж шаардлагатай тохиолдолд дайчлан ажиллуулах.
	СЯ	<ol style="list-style-type: none"> 1. Томуугийн цартахлын вакциныг түгээх үйл ажиллагааны зардлын тооцоог хянан засварлаж, эцэслэнэ. 2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлсэн
	ЗТАЖЯ	<p>Томуугийн цартахлын вакциныг 7 хоногт эцсийн хэрэглэгчдэд аюулгүй хүргэнэ.</p>
	Хэвлэлийн төлөөлөгч	<ol style="list-style-type: none"> 1. Олон нийттэй харьцах харилцаа холбооны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. 2. Олон нийтэд зориулсан мэдээлэл сургалт, сурталчилгааны материал боловсруулна. 3. Олон нийтийг мэдээллээр хангана.

	ТББ	<ol style="list-style-type: none"> 1. Хүн хүч, тоног төхөөрөмжийн нэмэлт эх үүсвэрээр хангах. 2. Олон нийтийн дайчилгаанд оролцох. 3. Сургалт зохион байгуулахад оролцох.
--	-----	--

Тухайн шатлал бүрийн комиссын бүрэлдэхүүн:

1. Комиссын дарга- / Засаг дарга/
2. Нарийн бичгийн дарга- /ЭМГ, ЭМН-ийн дарга/
3. Гишүүд
 - ОБГ, хэлтэс
 - Халдвар судлагч
 - Вакцин хариуцсан их эмч
 - Хэвлэлийн төлөөлөгч
 - ТББ

Комисс нь тухайн шатлалын эрүүл мэндийн байгууллага дээр байрлаж, 24 цагийн ажиллагаатай суурин утас, факсын аппарат/гар утсаар холбоо барих нөхцлөөр хангагдсан байна.

Улсын комисс – ХӨСҮТ, Дархлаажуулалтын алба

Аймгийн комисс – Аймгийн ЭМГ

Дүүргийн комисс – Дүүргийн ЭМН

Сумын комисс – Сумын эмнэлэг

2.2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оролцогч талууд, комиссын ажил үүргийн хуваарийн үлгэрчилсэн загвар:

1. Томуугийн цартахлын вакциныг шуурхай түгээх төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.
2. Салбар хоорондын уялдаа холбоог хангана.
3. Вакцин, дагалдах хэрэгслийг түгээх үеийн мэдээлэл, харилцаа холбоог хангана.
4. Вакцин, дагалдах хэрэгслийг түгээх, хадгалах үеийн аюулгүй байдлыг хангана.
5. Вакцин, дагалдах хэрэгслийг холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн улсын хилээр нэвтрүүлнэ.
6. Вакцин, дагалдах хэрэгслийг эцсийн хэрэглэгчдэд түгээх ажлыг гардан зохион байгуулна.
7. Вакцин, дагалдах хэрэгслийг түгээх явцад учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээг урьдчилан хийж, эрсдэл учирсан тохиолдолд тухай бүрт нь шийдвэрлэнэ.
8. Вакцин, дагалдах хэрэгслийг түгээх явцад гарах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлсэн байна.
9. Ажиллагсдын аюулгүй байдлыг хангана.
10. Томуугийн цартахлын дархлаажуулалтын явцад үүсэх хог хаягдлын менежментийг зохицуулна.
11. Хүн хүч, тоног төхөөрөмжийн нөөцийг нэмэлтээр бүрдүүлсэн байна.

12. Томуугийн цартахлын вакциныг түгээх үндэсний төлөвлөгөөтэй уялдуулан холбогдох дэд төлөвлөгөөнүүдийг (үйл ажиллагаа, хүний нөөц, харилцаа холбоо, хог хаягдлын менежмент, түгээх зураглал, сургалт) боловсруулан хэрэгжүүлнэ.
13. Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, эцсийн үр дүнд хяналт тавин холбогдох дээд шатны байгууллагад тайлагнана.

Комиссын гишүүн нэг бүрийн ажил үүргийн хуваарийг Хүснэгт 2-т харуулсан болно.

Томуугийн цартахлын вакциныг шуурхай түгээх үйл явцтай холбоотой аливаа шийдвэрийг тухайн шатны комисс нь цаг үеийн нөхцөл байдлыг үнэлж, дээд шатны комисстой зөвшилцсөний үндсэн дээр гаргаж байх болно.

Томуугийн цартахлын вакциныг шуурхай түгээх үндэсний төлөвлөгөөний дэд төлөвлөгөөнүүдэд Томуугийн цартахлын вакцинжуулалтын үеийн мэдээлэл, харилцаа холбооны төлөвлөгөө, Хүний нөөц, сургалтын төлөвлөгөө, Томуугийн цартахлын вакцинжуулалтын явцад үүссэн эмнэлгийн хог хаягдлын менежмент зэрэг багтана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО

3.1. Мэдээллийн тогтолцоо, урсгал

Онгоцоор вакцин тээвэрлэдэг 9 аймаг (Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Дорнод, Завхан, Өмнөговь, Увс, Ховд, Хөвсгөл), галт тэргээр тээвэрлэдэг 5 аймаг (Орхон, Сэлэнгэ, Дорноговь, Дархан-Уул, Говьсүмбэр), машинаар тээвэрлэдэг 7 аймаг (Архангай, Булган, Хэнтий, Дундговь, Өвөрхангай, Сүхбаатар, Төв)-т ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албанаас аймгийн ЭМГ-ын дархлаажуулалт хариуцсан халдвар судлагч их эмчид вакцин илгээсэн тухай утсаар мэдэгдэнэ. Томуугийн цартахлын вакциныг хүлээн авснаас хойш 12 цагийн дотор вакцин хүлээн авсан тухай эргэн мэдээлэх хуудас (Хавсралт 3)-ыг бөглөж 45-17-98 тоот утсанд мэдэгдэнэ.

Томуугийн цартахлын вакциныг аймгийн ЭМГ-т тээвэрлэн хүргэснээс хойш 1 хоногт багтаан сумдад хүргүүлнэ. Уг вакцинг сумдын эмнэлэг хүлээн авсан тухай эргэн мэдээлийг 8 цагийн дотор сумдаас утсаар авч нэгтгэн (Хавсралт 4) ХӨСҮТ-ийн 45-17-98 тоот утсанд эргэн мэдэгдэнэ.

Улаанбаатар хотын 9 дүүргийн ЭМН-үүдэд томуугийн цартахлын вакциныг ХӨСҮТ-ийн хөргүүртэй машинаар "товлосон өдөр" тараана. Томуугийн цартахлын вакциныг дүүргийн ЭМН-д хүргэж өгөхөөс 2 хоногийн өмнө дүүргийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албанаас утсаар урьдчилан мэдэгдэн агуулах савыг бэлдүүлсэн байна. Томуугийн цартахлын вакциныг хуваарийн дагуу дүүргүүдэд хүргэж өгсөн даруйдаа вакцин хүлээн авсан тухай тэмдэглэлийг үйлдэж, хүлээн авсан вакцины хадгалалтын горимыг шалган, гарын үсэг зурж баталгаажуулна. (Хавсралт 4)

ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын алба нь тухайн аймаг, дүүргээс ирүүлсэн томуугийн цартахлын вакцин хүлээн авсан тухай эргэн мэдээллийг утас, факсаар хүлээн авч дууссанаас хойш 2 цагийн дотор нэгтгэн улсын комисст мэдээлнэ (Хавсралт 5).

Сумдууд вакцин хүлээн авсан тухай эргэн мэдээллийг (Хавсралт 6) аймагт вакцин илгээснээс хойш 4 хоногт багтаан ХӨСҮТ авч, нэгтгэн улсын комисст танилцуулна.

Вакцин дагалдах хэрэгсэлийн хангамж нийлүүлэлттэй холбоотой мэдээлэл

- Вакцин, дагалдах хэрэгслийн тоо хэмжээ (илгээсэн, хүлээн авсан, тараасан, зарцуулсан, устгасан, хорогдол, үлдэгдэл)
- Шуурхай түгээлтийн үед хэрэглэх мэдээ болон тайлангийн маягтууд
- Вакцин, дагалдах хэрэгсэл түгээх нэгжийн байршлын зураглал, тээврийн хэрэгслийн төрөл, маршрут, онгоц, галт тэрэгний хуваарь - /ОБЕГ, ОБГ, ОБХ/
- Вакцин, дагалдах хэрэгслийг төвөөс аймаг/дүүрэг, аймаг/дүүргээс сум/өрхийн эмнэлэг хүртэл тээвэрлэх хугацааг нарийвчлан гаргасан байх - /ОБЕГ, ОБГ, ОБХ/

3.2. Харилцаа холбооны дэд төлөвлөгөө

Комисс нь тухайн шатлалын эрүүл мэндийн байгууллага дээр байрлан, түгээх үйл явц дуустал байнгын ажиллагаатай суурин утас, гар утас/факсын аппаратаар хангагдсан байна.

- Улсын комисс – суурин утас, факсын аппарат, интернет холболт
- Аймаг, дүүргийн комисс – суурин утас, факсын аппарат, интернет холболт
- Сумын комисс – гар утас, суурин утас/факсын аппарат

Комиссын үйл ажиллагааны зардалд харилцаа холбооны зардлыг (факсын цаас, хор, утасны зардал) тусгайлан тусгаж өгсөн байх шаардлагатай.

3.2.1. Вакцины төв агуулахаас аймгуудад вакцин, дагалдах хэрэгсэл тээвэрлэх үеийн харилцаа холбоо:

ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албаны хүйтэн хэлхээ хариуцсан их эмч аймгийн вакцин, дагалдах хэрэгслийг хуваарийн дагуу ачуулсан даруйдаа харилцаа холбоо хариуцсан ОБЕГ-ын холбогдох мэргэжилтэнд доорх мэдээллийг утсаар өгнө. Үүнд:

1. Вакцин, дагалдах хэрэгсэл хүлээн авах аймгийн нэр
2. Илгээсэн вакцин, дагалдах хэрэгслийн тоо хэмжээ
3. Тээвэрлэгчийн нэр, албан тушаал, холбоо барих утас
4. Жолоочийн нэр, холбоо барих утас
5. Тээврийн хэрэгслийн төрөл, дугаар (авто машины улсын дугаар, марк, нислэг/галт тэрэгний дугаар)
6. Тээврийн хэрэгсэл ХӨСҮТ-ийн хүйтэн өрөөнөөс хөдөлсөн цаг, минут

3.2.2. Вакцины төв агуулахаас дүүрэг: вакцин, дагалдах хэрэгсэл тээвэрлэх үеийн харилцаа холбоо:

ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албаны хүйтэн хэлхээ хариуцсан их эмчийн шууд удирдлагаар вакцин, дагалдах хэрэгслийг зориулалтын хөргүүртэй авто машинаар тээвэрлэн дүүргийн ЭМН-үүдэд 1 өдөрт багтаан хүргэсэн байна. Дүүргийн ЭМН рүү тээвэрлэхийн өмнө ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албанаас харилцаа холбоо хариуцсан нийслэлийн ОБХ-ийн холбогдох мэргэжилтэнд доорх мэдээллийг утсаар өгнө.

Үүнд:

1. Хөргүүртэй машин ХӨСҮТ-ийн хүйтэн өрөөнөөс хөдөлсөн цаг, минут
2. Дүүргийн ЭМН-үүдэд очих хуваарь
3. Тээвэрлэгчийн нэр, албан тушаал, холбоо барих утас
4. Жолоочийн нэр, холбоо барих утас
5. Авто машины улсын дугаар, марк

3.2.3. Аймгийн төвөөс сумдад вакцин, дагалдах хэрэгсэл тээвэрлэх үеийн харилцаа холбоо:

Аймгийн ЭМГ-ын дархлаажуулалт хариуцсан их эмч сумын вакцин, дагалдах хэрэгслийг хуваарийн дагуу тээвэрлэгчид ачуулсан даруйдаа харилцаа холбоо хариуцсан аймгийн ОБГ, ОБХ-ийн холбогдох мэргэжилтэнд дараах мэдээллийг утсаар өгнө. Үүнд:

1. Вакцин, дагалдах хэрэгсэл хүлээн авах сумын нэр
2. Илгээсэн вакцин, дагалдах хэрэгслийн тоо хэмжээ
3. Тээвэрлэгчийн нэр, албан тушаал, холбоо барих утас
4. Жолоочийн нэр, холбоо барих утас
5. Авто машины улсын дугаар, марк
6. Авто машин аймгийн ЭМГ-аас хөдөлсөн цаг, минут

Вакцин, дагалдах хэрэгсэлийг ачуулан явуулсан тухай мэдээлэл хүлээн авсан ОБЕГ/ОБГ, ОБХ-ийн холбогдох мэргэжилтэн вакцинг эцсийн цэгт очих хүртэлх хугацааны туршид харилцаа холбоог хариуцна. Тээвэрлэлтийн хугацаанд харилцаа холбоо хариуцсан мэргэжилтэн нь тээвэрлэгчтэй 1-ээс дээш удаа утсаар холбогдож тээвэрлэлтийн явцын талаарх мэдээллийг авна. Тээврийн хэрэгсэл хөдөлсөн тухай мэдээлэл өгсөн болон мэдээлэл хүлээн авсан талууд тэмдэглэл үйлдэж баримтжуулсан байна. Тээвэрлэгч болон жолооч нар тээвэрлэлтийн явцад дараах хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

- Гар утасны цэнэг нь хангалттай байх
- Гар утасны нөөц зайтай байх
- Гар утсыг байнга асаалттай байлгах
- Гар утасны ярианы нэгж хангалттай байх
- Тухайн шатны харилцаа холбоо хариуцсан мэргэжилтэнтэй холбоо барих утасны дугаар (Хавсралт 1)-ыг авсан байх
- Тээвэрлэлтийн явцад бэрхшээл тулгарвал харилцаа холбоо хариуцсан мэргэжилтэнд даруй мэдэгдэх.
- Тээвэрлэж буй вакцин, дагалдах хэрэгслийн аюулгүй, бүрэн бүтэн байдлыг хариуцах.
- Тээвэрлэгч зорьсон газарт очсон даруйдаа ирсэн тухайгаа харилцаа холбоо хариуцсан мэргэжилтэнд утсаар мэдэгдэх.

Харилцаа холбоо хариуцсан мэргэжилтэн нь гар утасны сүлжээ барьдаггүй газар нутгаар тээвэрлэгч дайран өнгөрөх эсэх, хэрэв тийм бол сүлжээгүй газраар явахад хэдий хугацаа зарцуулах талаар урьдчилан судлаж тодорхойлсон байна. Уг судалгаанд үндэслэн гар утасны сүлжээ барьдаггүй нутаг дэвсгэрт нэвтрэхийн өмнө, тухайн нутгаар дайран өнгөрсний дараа тээвэрлэгчтэй тус тус холбогдон тээвэрлэлтийн явцын талаарх мэдээллийг авна. Гар утасны сүлжээ барьдаггүй нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх товлосон хугацаанаас 2 цаг ба түүнээс дээш хугацаанд холбоо тогтоож чадахгүй тохиолдолд харилцаа холбоо хариуцсан мэргэжилтэн нэмэлт хүн хүч, машин техникийг илгээнэ. Томуугийн цартахлын вакцин, дагалдах хэрэгсэл түгээх үйл ажиллагаа дуусах хүртэл ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албаны 45-17-98 тоот утсанд ажлын цагаар хариуцлагатай жижүүр ажиллуулна. Тухайн өдрийн хариуцлагатай жижүүр нь ажлын бус цагаар гар утсаа байнга нээлттэй байлгана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ВАКЦИНЫ ХҮЙТЭН ХЭЛХЭЭ, ШУУРХАЙ ТҮГЭЭЛТ

4.1. Вакциныг хадгалах хүйтэн хэлхээний багтаамж

Томуугийн цар тахлын вакциныг +2 +8 хэмд хадгалах буюу тээвэрлэнэ. Дархлаажуулалтын алба нь хүйтэн хэлхээний нийт багтаамж, товллын вакцины багтаамж, цартахлын вакцины багтаамжийг үндэсний, аймаг, дүүрэг, сум, өрхийн эмнэлгийн түвшинд тус тус урьдчилан бодож тооцоолсон байна. Тухайн түвшний дархлаажуулалт хариуцсан их эмч томуугийн цартахлын вакцин, дагалдах хэрэгслийг агуулах байр савыг бэлдэж, дархлаажуулалтын нэгжүүдэд тараах хуваарийг гарган холбогдох хүмүүст нь урьдчилан мэдэгдэж тээврийн хэрэгсэл болон зөөвөрлөх сав, мөсөн элементийг бэлдүүлсэн байна. Хүлээн авсан цартахлын вакцины тоо хэмжээ, бүрэн бүтэн байдал, тээвэрлэлтийн горим зэргийг шалгаж аваад вакцин хүлээн авсан тухай маягт бөглөн вакцин илгээсэн газарт утас, факсаар мэдэгдэнэ. Мөн доод шатны дархлаажуулалтын нэгжүүдэд вакцин, дагалдах хэрэгслийг тараасан тухай мэдээллийг вакцин анх илгээсэн газарт эргэн мэдээлнэ.

Монгол улсын вакцин, биобэлдмэл хадгалах төв агуулах нь улсын хэмжээнд вакцин, биобэлдмэл болон дагалдах хэрэгслүүдийг хадгалах, түгээх үйл ажиллагааг явуулдаг. Тус агуулах нь :

1. +2⁰C - +8⁰C хэмийн 25,830 литр
2. -15⁰C - -25⁰C хэмийн 10,509 литр

3. Хуурай агуулах 161,500 литр тус тус багтаамжтай болно. (Зураг 2)

Одоо эдгээр агуулах тус бүрт +4⁰с хэмд 5893 литр эзлэгдсэн ба 13,292 литр чөлөөтэй, -20⁰C хэмд 1,003 литр эзлэгдсэн ба 9,506 литр чөлөөтэй, хуурай агуулахад 51,076 литр эзлэгдсэн ба 110,424 литр чөлөөтэй байгаа юм. (Зураг 4)

Түүнчлэн дархлаажуулалтын нэгжүүдийн түвшин бүрийн одоо хадгалж байгаа вакцин, биобэлдмэл ба чөлөөтэй байгаа багтаамжийг тооцон үзэх шаардлагатай. (Зураг 1,3, Хүснэгт 3)

Хүснэгт 3

№	Түвшин	+2 ⁰ C+8 ⁰ C-д хадгалах нийт багтаамж, литр	Байнгын вакцины эзлэж байгаа хэмжээ	Нийт +2 ⁰ C+8 ⁰ C-д хадгалах боломжтой хэмжээ	Нийт хүн амын 4%-д хийх H1N1-ийн вакциныг хадгалахад шаардлагатай нийт багтаамж	Нийт хүн амын 6%-д хийх H1N1-ийн вакциныг хадгалахад шаардлагатай нийт багтаамж	Нийт хүн амын 15%-д хийх H1N1-ийн вакциныг хадгалахад шаардлагатай нийт багтаамж
1	Улс	25,830.00	5,893.00	19,937.00	1,128.00	1,827.00	4,568.00
2	Аймаг	238.60	76.50	162.10	27.00	41.00	102.00
3	Дүүрэг	151.7	45.10	106.60	53.00	79.00	197.00
4	Өрхийн эмнэлэг/ сумын	17.37	4.20	13.17	1.00	2.00	5.00

эмнэлэг						
---------	--	--	--	--	--	--

4.2. Дархлаажуулах үйл ажиллагаа

Томуугийн цартахлын эсрэг дархлаажуулалтыг заавал хийх дархлаажуулалтын үйл ажиллагааны тогтолцоог ашиглан хэрэгжүүлнэ.

Томуугийн цартахлын эсрэг дархлаажуулалт нь богино хугацаанд олон хүнийг вакцинд хамруулах шаардлагатай тул нэмэлт хүн хүчийг төлөвлөн, хүйтэн хэлхээний чадавх, вакциныг түгээх, аюулгүй хадгалах зэрэг асуудлыг урьдчилан төлөвлөсөн байна.

Томуугийн цартахлын A/H1N1/ вирусийн халдвараас сэргийлэх дархлаажуулалтыг Эрүүл мэндийн сайдын тушаал, ХӨСҮТ-ийн мэргэжил арга зүйн удирдлагын дагуу тухайн нутаг дэвсгэрийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн нэгдэл нь зохион байгуулна. Үүнд:

1. Аймаг, нийслэлийн өрхийн эмнэлэг, Эрүүл мэндийн нэгдэл, төвүүд нь дархлаажуулалтад хамрагдах эрсдэлт бүлгийн (халдвартай нөхцөлд ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтэн, жирэмсэн эхчүүд, уушигны архаг өвчтэй хүмүүс ...гм) хүн амын нэр, нас хүйс, хаяг, регистрийн дугаар, ажил эрхлэлтийн байдлын дэлгэрэнгүй бүртгэл, жагсаалтыг урьдчилан гарган аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын даргаар баталгаажуулан цаасан болон цахим хэлбэрээр Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Тандалт, сэргийлэлт хариуцсан дэд захиралд ирүүлнэ.
2. Дархлаажуулалтыг сайн дурын үндсэн дээр зохион байгуулна. Дархлаажуулалтад хамрагдах зөвшөөрлийг бичгээр баталгаажуулж авна.
3. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь тухайн нутаг дэвсгэрийн өрхийн эмнэлэг бүрт вакцин тарих өрөө, вакцин тарихын өмнө эмчийн үзлэг хийх өрөөг урьдчилан бэлтгэсэн байна.
4. Дархлаажуулах хүн бүрийг эмчийн үзлэгт оруулж, дархлаажуулалт хийсний дараа 30 минут эмчийн хяналтад байлган зөвлөмж өгнө.
5. Өрхийн эмнэлэг бүр явуулын баг томилон вакциныг ирж тариулах боломжгүй хүн амыг дархлаажуулах ба баг бүр 2 ширхэг вакцин зөөврийн савтай (мөсөн элемент, хэм заагуурын хамт) байна.
6. Дархлаажуулалтыг хийх эмч, сувилагч нарт мэргэжил арга зүйн сургалт зохион байгуулна.
7. Дархлаажуулалтад хамрагдвал зохих хүн амын 80-90 хувийг дархлаажуулалтын эхний 3 өдөрт багтаан хийхээр төлөвлөнө.
8. Вакцин тарьсны дараа тохиолдож болзошгүй урвал, хүндрэлийн үед хэрэглэх яаралтай тусламжийн эмүүдийг (адреналин, анальгин, атрофин, кордиамин, дексаметазон, преднизолон, эуфиллин, эфедрин гэх мэт) бэлтгэнэ.

9. Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн тандалтыг хийж хүндрэл гарсан тохиолдолд Эрүүл мэндийн сайдын 2004 оны 242 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу мэдээлж судалгаа дүгнэлт гаргана.
10. Дархлаажуулалтын ажлын явцад аймаг, нийслэлийн ЭМГ, ХӨСҮТ-өөс ажлын байран дахь дэмжлэгт хяналт хийж мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.
11. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрууд ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албаны 451798 утсанд батлагдсан мэдээний маягтын дагуу өдөр бүр мэдээлж, дархлаажуулалт дууссан үед дархлаажуулалтын нэгдсэн тайлан бичиж албан бичгээр хүргүүлнэ.
12. Сайн дурын дархлаажуулалтыг Эрүүл мэндийн сайдын 2001 оны 34 тоот тушаалын хоёрдугаар хавсралтад заасан журмын дагуу хийнэ.

4.2.1 Халдвартай нөхцөлд ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтэнг дархлаажуулах

1. Эрүүл мэндийн байгууллага нь томуугийн халдварт өртөх эрсдэл бүхий эмч, эмнэлгийн мэргэжилтний нэрсийн жагсаалт гарган дарга, захирлаар баталгаажуулан аймаг, нийслэлийн ЭМГ-т ирүүлнэ.
2. Эрүүл мэндийн байгууллага нь өөрийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулна. Тухайн эрүүл мэндийн байгууллага нь аймагт харьяа Эрүүл мэндийн газраас, нийслэлд ХӨСҮТ, нийслэлийн ЭМГ-гаас хамрагдвал зохих хүний тоогоор вакцин, зүү тариурыг авна.

4.2.2 Жирэмсэн эмэгтэйчүүдийг дархлаажуулах

Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн нэгдлийн дархлаажуулалтын асуудал хариуцсан халдвар судлагч, жирэмсний хяналтын эмч нар хамтран дархлаажуулалтад хамрагдвал зохих жирэмсэн эмэгтэйчүүдийн нэрсийг гарган даргаар баталгаажуулсан байна.

1. Жирэмсний хяналтын эмч нар батлагдсан нэрсийн жагсаалтын дагуу жирэмсэн эмэгтэйчүүдийг дархлаажуулалтад богино хугацаанд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулна.
2. Дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн хяналтад байгаа жирэмсэн эмэгтэйчүүдийг дархлаажуулахын өмнөх эмчийн үзлэгийг жирэмсний хяналтын эмч нар, өрхийн эмчийн хяналтад байгаа бол өрхийн эмч нь хийнэ.
3. Дүүргийн эрүүл мэндийн нэгдлээс мэргэжлийн эмч нарын баг томилон жирэмсэн эмэгтэйчүүдэд вакцины дараа гарч болзошгүй урвал, хүндрэл, вакцин хийсэнтэй давхцаж илэрсэн аливаа эмгэгийг тандан эрт илрүүлж, эмнэлгийн тусламж үзүүлнэ.

4.2.3 Онцгой байдал, хил гааль, мэргэжлийн хяналт, агаарын болон төмөр замын тээврийн албан хаагчдыг дархлаажуулах

1. Нийгмийн үйлчилгээний нэн шаардлагатай ажил үйлчилгээ гүйцэтгэдэг дээрх байгууллагын хүмүүсийн нэрсийн жагсаалтыг тухайн салбарын ерөнхий газар, агентлаг, удирдах газар зэрэг байгууллага нь гарган тухайн аймаг, нийслэлийн ЭМГ-т ирүүлнэ.
